



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/493

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цацаг”ХХК-ний хийж гүйцэтгэсэн Жаргалант сумын Толхын ойлын 1, 2 дугаар байрны гадна шугам шинэчлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Б.Бурмаа -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга

Б.Бямбажав - “Цацаг”ХХК-ний захирал

Нарийн бичгийн


дарга:

С.Өнөржаргал

-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Цацаг”ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн дотор багтаан захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ